



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-3-21 № 04/27

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Б.БАДАМСҮРЭН ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Хан-Уул дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2012 оны санхүүгийн тайланд 49,7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

2012 оны 12 дугаар сарын 10-аас 2013 оны 2 дугаар сарын 1-ийг хүртэл 50 хоногийн хугацаатай "Хүнс тэжээл, нийгмийн халамжийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр тендер зарлаж, "Чандмань-Ээж" ХХК-д 26,2 сая, "Нийгмийн эмзэг бүлэг амжиргааны түвшин доогуур хүүхэд залуучуудыг дэмжих төв" ТББ-д 13,5 сая, "Сайн үйлс сэтгэлийн дуудлага" ТББ-д 10,0 сая нийт 49,7 сая төгрөг олгосон боловч холбогдох анхан шатны баримтыг дутуу бурдүүлсэн, зардлын гүйцэтгэл болон, гэрээ дүгнээгүй, ажлын хөлсийг 100 хувь урьдчилж өгсөн зэрэг зөрчил илэрсэн нь НББ-ийн тухай хуулийн 7дугаар зүйлийн 7.7-д "Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг, ХАХНХ-ын сайдын 2012 оны 10 дугаар сарын 29-ний А/51 тоот тушаалаар баталсан "Гэр оронгүй тэнэмлэл амьдралтай иргэнд үзүүлэх халамжийн үйлчилгээний журам"-ын 10.1.1, 10.1.2-д заасныг тус тус зөрчсөн байна.


"Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Бурдэл дутуу баримтаар олгосон 49,7 сая төгрөгийн гэрээний гүйцэтгэлийн холбогдох баримт материал, тайлан тооцоог хийж, биелэлтийг гарган 2013 оны 4 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хан-Уул дүүргийн Нийгмийн халамж үйдчилгээний хэлтсийн дарга Б.Бадамсүрэн, ерөнхий нягтлан бодогч Х.Оюунбилэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА:

БИЧСЭН:

Үндэсний аудитын газрын
Аудитор



Ш.Отгонбаяр

УХА0122

ХҮЛЭЭН АВСАН:

СБДүүргийн нийгмийн халамж
үйлчилгээний хэлтсийн дарга

Б.Бадамсүрэн

Ерөнхий нягтлан бодогч
Х.Оюунбилэг